

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 сарын 21-ний өдрийн
06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Компанийн оноосон нэр: “Монгол базальт” хувьцаат компани

Компанийн хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 29-р хороо, Үйлдвэрийн бүс 1-35 тоот

Хурал болох газар: Монголын хөрөнгийн биржийн сургалт, мэдээллийн танхим /хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Сүхбаатарын талбай-3/

Хурал болох өдөр, цаг: 2026 оны 04 сарын 30-ний өдрийн Пүрэв гаригт 10.00 цагт

Хурал болох хэлбэр: Танхим

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2026 оны 04 сарын 15-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

- 1.“Монгол базальт” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах
- 2.“Монгол базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай

Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:

- 1.Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг
- 2.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр
- 3.Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан
- 4.Компанийн 2025 оны санхүүгийн тайлан
- 5.“Нексия глобал монголиа аудит” ХХК-ийн хөндлөнгийн аудитын дүгнэлт
- 6.Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
- 7.Ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоол
- 8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн анкет, нэр дэвшүүлэх хорооны дүгнэлт
- 9.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын материалтай 2026 оны 03 сарын 31-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 10.00-16.00 цагийн хооронд өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани болон Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, “Фламинго тауэр”-ийн 7 давхарт компанийн төв оффисын аль нэгт очиж эсхүл www.basaltwool.mn цахим хуудсаар дамжуулан танилцах боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээллийг 75114444 утсаар авч болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



МОНГОЛ БАЗАЛТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 21-ний өдөр

№ 06

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дах заалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2, 6.3, 6.4 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн эчнээ санал хураалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 сарын 30-ны өдрийн Пүрэв гаригийн 10.00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Сүхбаатрын талбай-3 хаягт байрлах Монголын хөрөнгийн биржид танхимын хэлбэрээр зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - “Монгол базальт” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах
 - “Монгол базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2026 оны 03 сарын 24-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Билгүүн/-д даалгасугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 сарын 15-ны өдрөөр тогтоосугай.
5. “Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, Компанийн цахим хуудас болон өдөр тутмын “Өдрийн сонин”-оор 2026 оны 03 сарын 26-ний өдөр олон нийтэд мэдээлж, зарын давталтыг 2026 оны 04 сарын 10-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин олон нийтэд мэдээлсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, танилцуулга зэрэг баримт бичгийг 2026 оны 03 сарын 31-ний өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Билгүүн/-д даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарын загварыг нэгдүгээр хавсралтаар, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, хурлын саналын хуудасны загварыг гуравдугаар хавсралтаар, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох саналын хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг, хурлын хөтөлбөрийг тавдугаар хавсралтаар баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн П.Нямдорж, хурал зохион байгуулах комиссын гишүүдээр О.Билгүүн, Ц.Мэндбаяр, Т.Ууганцэцэг нарыг томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилсан байдлаар 2026 оны 04 сарын 28-ны өдрийн 17.00 цаг хүртэл хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэр 7 давхарт байрлах компанийн төв оффист бичгээр урьдчилан авах боломжийг бүрдүүлж ажиллахыг хурал зохион байгуулах комиссын дарга / П.Нямдорж/-д даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Н.Сугарсүрэн, тооллогын комиссын гишүүдээр Б.Уранбилэг, Б.Амаржаргал нарыг томилсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид зааснаар Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Билгүүн/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 сарын 21-ний өдрийн
06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн нэр
1	“Монгол базальт” ХК-ийн ТУЗ-ийн тогтоол, хавсралтуудын хамт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай 2026.03.21- ны өдрийн Дугаар 06
2	“Монгол базальт” ХК-ийн 2025 оны Үйл ажиллагааны тайлан
3	“Монгол базальт” ХК-ийн 2025 оны Санхүүгийн тайлан “Нексия глобал монголиа аудит” ХХК-ийн хөндлөнгийн аудитын дүгнэлт
4	“Монгол базальт” ХК-ийн 2025 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн өгсөн дүгнэлт
5	Төлөөлөн удирдах зөвлөлийн Ногдол ашиг тараах тухай 2026.02.16-ны өдрийн Дугаар 02 тогтоол
6	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн анкет, нэр дэвшүүлэх хорооны дүгнэлт
7	Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 сарын 21-ний өдрийн
06 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



BASALTWOOL
МОНГОЛ БАЗАЛТ ХК

**“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Санал хураах арга: Энгийн

Хувьцаа эзэмшигчийн овог: _____

Хувьцаа эзэмшигчийн нэр: _____

Регистрийн дугаар: _____

Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа тохиолдолд

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Брокерийн компанийн нэр: _____

“Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 сарын 30-ны өдрийн Пүрэв гаригийн 10.00 цагт

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах			

Хувьцаа эзэмшигч /итгэмжлэгдсэн төлөөлөгч/-ийн гарын үсэг _____ /

Санал авах хуудас үйлдсэн: 2026 оны ___ сарын ___ өдөр

Саналын хуудасыг хүчинтэйд тооцсон эсэх: _____

Тооллогын комиссын дарга _____ /Н.Сугарсүрэн/

Саналын хуудасыг хүчингүйд тооцсон шалтгаан: _____

Санамж:

- 1.1.Хувьцаа эзэмшигч нь саналын хуудасыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ /+/ тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн хүснэгтэд /+/ тэмдэглэгээ хийнэ.
- 2.2.Санал авах хуудасны эхний хэсгийг зуучлагч үнэт цаасны компанийн тэмдэг даран баталгаажуулж хувьцаа эзэмшигчдэд өгнө.
- 3.3.Засварласан, балласан залруулагатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- 4.4.Хувьцаа эзэмшигчид нь 2026 оны 04 сарын 30-ны дотор хурлын материалтай танилцах бөгөөд өөрийн биеэр оролцох боломжгүй тохиолдолд 2026 оны 04 сарын 28-ны 17.00 цагаас өмнө санал авах хуудсанд саналаа тэмдэгдлэн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хүргүүлнэ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 сарын 21-ний өдрийн
06 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт



BASALTWOOL
МОНГОЛ БАЗАЛТ ХК

**“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Санал хураах арга: Кумулятив

Хувьцаа эзэмшигчийн овог: _____

Хувьцаа эзэмшигчийн нэр: _____

Регистрийн дугаар: _____

Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа тохиолдолд

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Брокерийн компанийн нэр: _____

“Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 сарын 30-ны өдрийн Пүрэв гаригийн 10.00 цагт

№	Хэлэлцэх асуудал	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч	Саналын эрхийн тоо
1	ТУЗ-ийн ердийн гишүүнийг сонгох	Л.Ариунболд	
		П.Сайнбилэг	
		А.Энхгэрэл	
		Г.Ганзориг	
		Б.Шаравсамбуу	
		Хан Гю Бунг	
2	ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох	П.Нямдорж	
		Ч.Зоригтбаатар	
		Б.Онон	
		Ш.Энхтөр	

Хувьцаа эзэмшигч /итгэмжлэгдсэн төлөөлөгч/-ийн гарын үсэг _____ /

Санал авах хуудас үйлдсэн: 2026 оны ___ сарын ___ өдөр

Саналын хуудасыг хүчинтэйд тооцсон эсэх: _____

Тооллогын комиссын дарга _____ /Н.Сугарсүрэн/

Саналын хуудасыг хүчингүйд тооцсон шалтгаан: _____

Санамж:

- 1.1.Хувьцаа эзэмшигч нь саналын хуудасыг бөглөхдөө санал өгөх хэсэгтаа /+/ тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн хүснэгтэд /+/ тэмдэглэгээ хийнэ.
- 2.2.Санал авах хуудасны эхний хэсгийг зуучлагч үнэт цаасны компанийн тэмдэг даран баталгаажуулж хувьцаа эзэмшигчдэд өгнө.
- 3.3.Засварласан, балласан залруулагатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- 4.4.Хувьцаа эзэмшигчид нь 2026 оны 04 сарын 30-ны дотор хурлын материалтай танилцах бөгөөд өөрийн биеэр оролцох боломжгүй тохиолдолд 2026 оны 04 сарын 28-ны 17.00 цагаас өмнө санал авах хуудсанд саналаа тэмдэгдлэн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хүргүүлнэ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 сарын 21-ний өдрийн
06 дугаар тогтоолын тавдугаар хавсралт



“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

1. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол базальт ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн холбогдох дүрэм журам, заавар, компанийн дүрэм болон энэхүү дэгийг баримтлан зохион байгуулна.

2. Хурлын дарга, түүний эрх үүрэг

2.1 Хурлын дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр эсхүл хурлын даргыг томилсон шийдвэрт заасан этгээд байна.

2.2 Хурлын дарга дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

2.2.1 Хурлын дарга нь хурлын дэгийн дагуу удирдан явуулж, хуралд оролцогчдоос хурлын дэгийг сахин биелүүлэхийг шаардах

2.2.2 Хуралд оролцогчдод асуулт асуух зөвшөөрөл олгож, асуулт асуух хугацааг чанд мөрдүүлэх

2.2.3 Хуралдааны дэг зөрчсөн этгээдэд энэхүү дэгийн 7-д заасан хариуцлага тооцох

3. Хуралдаанд оролцох

3.1 Хуралд оролцогч нь хурал эхлэхээс 20 минутын өмнө бэлтгэлээ хангаж, бүртгэлээ баталгаажуулсан байна.

3.2 Хуралд оролцогч хувьцаа эзэмшигч иргэн нь танхимаар хуралд оролцохоор ирэхдээ өөрийн хүчин төгөлдөр иргэний үнэмлэхтэй ирнэ. Хэрэв итгэмжлэлийн үндсэн дээр өөрийн төлөөний хүнийг оролцуулах тохиолдолд хүчин төгөлдөр итгэмжлэлийг авч ирнэ.

3.3 Хуралд оролцогч хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага нь танхимаар хуралд оролцохоор ирэхдээ өөрийн компанийн хүчин төгөлдөр гэрчилгээ /эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/-тай ирнэ. Хэрэв итгэмжлэлийн үндсэн дээр өөрийн төлөөний хүнийг оролцуулах тохиолдолд хүчин төгөлдөр итгэмжлэлийн эх хувийг авчирна.

3.4 Хуралд оролцогчийг дараах тохиолдолд хуралд оролцуулахгүй, хурлын танхимаас гаргана. Үүнд:

3.4.1 Хувьцаа эзэмшигч биш байх

3.4.2 Хувьцаа эзэмшигчийн хуралд оролцох эрхтэйг гэрчлэх бичиг баримтгүй байх

3.4.3 Хүчин төгөлдөр бичиг баримтын шаардлага хангаагүй байх

3.4.4 Хурлын үеэр эмх, замбараагүй байдал бий болгох

3.4.5 Хурлын даргын сануулгыг удаа дараа зөрчих

3.4.6 Зүй бус үг хэллэг хэрэглэх, бусдыг дайрч доромжлох үйлдэл гаргах

3.5 Тооллогын комисс нь энэхүү дэгийн 3.4-т заасан үндэслэлээр тухайн этгээдийг хуралд оруулахгүй, хурлын танхимаас гаргана.

4.1. Асуулт, хариулт

- 4.1 Хуралд оролцогч нь хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт асууна. Асуулт асуух хугацаа 1 /нэг/ минут байна.
- 4.2 Хурлын дарга нь хэлэлцэх асуудлыг танилцуулсны дараа хуралд оролцогчдоос асуулт байгаа эсэхийг асууна.
- 4.3 Хурал зохион байгуулагч нь асуулт асуух, хувьцаа эзэмшигчдийг дараалалд оруулан овог, нэр асуултыг тэмдэглэж авна.
- 4.4 Асуултад компанийн эрх бүхий албан тушаалтан хариулна. Асуултад хариулах этгээд нь хэлэлцэх асуудалтай холбоогүй асуултад хариулахаас татгалзах эрхтэй.
- 4.5 Асуулт асуух хугацаа хэтэрсэн тохиолдолд хурлын дарга хугацаа дууссаныг сануулах бөгөөд сануулснаас хойш 30 секунд өнгөрмөгц хурлын дарга тухайн хүнийг асуултаа дуусгахыг шаардана.
- 4.6 Хувьцаа эзэмшигчид нь хуралд оролцож буй хөндлөнгийн аудитын байгууллагын төлөөлөгчөөс асуулт асууж болох ба энэхүү дэгийг баримтална.

5. Хэлэлцэх асуудалтай холбоотой санал өгөх

- 5.1 Хуралд оролцогч нь хурлын өмнө цахим бүртгэлд бүртгүүлэн, санал өгөх заавартай танилцсан байх бөгөөд тус заавар маягтын дагуу саналаа өгөөгүй бол тухайн саналыг хүчингүйд тооцно.
- 5.2 Урьдчилсан санал гэдэг нь хувьцаа эзэмшигчийн хурлын товлосон өдрөөс өмнө батлагдсан саналын хуудсаар цаасаар өгсөн хувьцаа эзэмшигчийн санал байна.
- 5.3 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах албан ёсны зарлалд тусгагдсан бүртгэлийн өдрөөс эхлэн урьдчилсан санал өгч болно. Урьдчилсан санал өгсөн тохиолдолд түүнийг дахин өөрчлөхгүй ба тус санал нь эцсийнх байна.
- 5.4 Хуралд оролцогч нь цахим болон цаасан хэлбэрээр өөр агуулгатай санал өгсөн тохиолдолд цаг хугацааны дарааллаар түрүүлж өгсөн саналыг хүчинтэйд тооцно.
- 5.5 Хуралд оролцогч нь хэлэлцэх асуудал тус бүрт нэг санал өгөх эрхтэй.
- 5.6 Хэлэлцэх асуудлын баримт бичгийн төсөл болон тогтоолын төсөлд санал өгөхдөө саналын хуудасны арын хэсэгт бичнэ.
- 5.7 Хуралд оролцогчоос баримт бичгийн төсөл болон тогтоолын төсөлд өгсөн саналыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь саналын товъёогт тусгана. Саналын товъёогт тусгахдаа тухайн хуралд оролцогчийн овог, нэр оруулах саналыг үнэн зөв, бүрэн гүйцэт тусгана.

6. Санал тоолох, саналыг нэгтгэн танилцуулах

- 6.1 Саналыг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор томилогдсон тооллогын комисс тоолж, нэгтгэнэ.
- 6.2 Тооллогын комиссын дарга нь саналыг нэгтгэж хурлын даргад танилцуулна.
- 6.3 Хуралд оролцогч нь цахим болон цаасан хэлбэрээр давхар санал өгсөн тохиолдолд цаг хугацааны дарааллаар сүүлийн өгсөн саналыг хүчинтэйд тооцно.
- 6.4 Урьдчилсан байдлаар саналаа өгсөн хувьцаа эзэмшигчийн тус хуралд оролцсонд тооцож бүртгэх ба саналын хуудасыг нэгтгэн тоолно.
- 6.5 Тооллогын комисс нь цахим системээр өгсөн саналыг шууд тоолж, цаасан хэлбэрээр өгсөн хүчин төгөлдөр саналыг цахим систем рүү оруулж, саналыг нэгтгэнэ.
- 6.6 Нийт саналыг нэгтгэсэн цахим системийн тайлан болон цаасан хэлбэрээр өгсөн саналыг хамт Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгч, бусад хурлын материалын хамт архивлана.

7. Хариуцлага

- 7.1 Хуралдааны дэг зөрчигчид хуралдаан даргалагч нь эхний удаа сануулна
- 7.2 Удаа дараа зөрчвөл хурлын танхимаас гаргана.



**“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР**

Нийт үргэлжлэх хугацаа: 3 цаг

Хугацаа	Хөтөлбөр	Хариуцагч
09.30-10.00	Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх	Хурал зохион байгуулах комисс
10.00-10.05	Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулах	Тооллогын комиссын дарга Н.Сугарсүрэн
10.05-10.10	Хурлын үйл ажиллагааг нээж, дэгийг танилцуулах	Хурлын дарга П.Нямдорж
10.10-10.40	Монгол базальт ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах	Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл
10.40-11.00	Асуулт хариулт	
11.00-11.20	Цайны завсарлага	
11.20-11.30	ТУЗ-ийн үйл ажиллагаа болон компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан, аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс өгсөн дүгнэлт танилцуулах	ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Зоригтбаатар
11.30-11.50	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн анкет танилцуулах	ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны дарга П.Нямдорж
11.50-12.00	Нэр дэвшигчдээс асуулт, хариулт	
12.00-12.05	Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх талаар танилцуулах	Тооллогын комиссын дарга Н.Сугарсүрэн
12.05-12.25	Санал хураалт – саналын хуудасаар	Тооллогын комисс
12.25-12.35	Санал хураалтыг нэгтгэн тоолох, танилцуулах	Тооллогын комисс
12.35-12.45	Хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, хурал хаах	Хурлын дарга П.Нямдорж



ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

П.НЯМДОРЖ

ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хувьцаа эзэмшигч танаа,

2025 он “Монгол Базальт” ХК-ийн хувьд тэсвэр хатуужил, стратегийн шинэчлэлийн жил байлаа. Бид макро эдийн засгийн сорилттой орчинд үйл ажиллагаа явуулсан хэдий ч эдгээр нөхцөлийг боломж болгон хувиргаж, компанийн урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэх суурийг амжилттай бэхжүүлж чадлаа.

Тайлант хугацаанд бид технологийн шинэчлэл, олон улсын стандартын нэвтрүүлэлтийг эрчимжүүлж, экспортын чадавхаа бэхжүүлэхэд онцгой анхаарлаа. Үүний зэрэгцээ хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, инженер, техникийн ажилтнуудынхаа мэдлэг, ур чадварыг олон улсын түвшинд хүргэх зорилтыг хэрэгжүүлж, ажиллах таатай орчин бүрдүүлсний үр дүнд боловсон хүчний эргэлтийг 2.5 хувьд хадгалж чадсан нь онцлох үр дүн боллоо.

Мөн “Дулаанбаатар” аяны хүрээнд эрчим хүчний хэмнэлтийн талаарх мэдлэг, ойлголтыг олон нийтэд түгээж, байгаль орчинд ээлтэй “ногоон үйлдвэрлэл”-ийг дэмжих чиглэлд манлайлан ажилласан нь компанийн нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн бодлогын чухал хэсэг байв.

Цаашид бид Компанийн засаглал болон үйлдвэрлэлийн удирдлагын оновчтой тогтолцоогоор дамжуулан бизнесийн тасралтгүй, тогтвортой өсөлтийг хангахыг эрмэлзэнэ.

Та бүхний бидэнд хүлээлгэсэн итгэл, тасралтгүй дэмжлэг болон харилцан ашигтай хамтын ажиллагаа нь бидний өнөөдрийн ололт амжилт, ирээдүйн үнэ цэнийн бат бөх суурь юм.

Хамтдаа илүү дулаан, тогтвортой ирээдүйг бүтээцгээе.

Хүндэтгэсэн,
Монгол Базальт ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
Л.Ариунболд

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түншүүд ээ,

2025 он “Монгол Базальт” ХК-ийн хувьд үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, технологийн шинэчлэлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх замаар зах зээлийн байр сууриа хадгалж, тогтвортой байдлыг хангахын төлөө ажилласан сорилт, амжилт хосолсон жил байлаа.

Тайлант хугацаанд дэлхий нийтийн болон дотоодын барилгын салбарын тогтворгүй байдлыг үл харгалзан бид дотоод нөөц боломжоо дээд зэргээр дайчлан, үйлдвэрлэлийн бүтээмж, зардлын удирдлагыг сайжруулахад төвлөрөн ажилласан. Үүний зэрэгцээ ISO нэгдсэн менежментийн тогтолцоог амжилттай хэрэгжүүлж, чанар, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлын удирдлагыг

олон улсын стандартын түвшинд баталгаажуулсан нь компанийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргасан чухал үр дүн боллоо.

Бид байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх “ногоон үйлдвэрлэл”-ийн бодлогыг тууштай хэрэгжүүлж, үйлдвэрлэлийн процессын сайжруулалт, нөөцийн үр ашигтай ашиглалтаар бүтээгдэхүүний өртөг зардлыг бууруулж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүллээ. ESG зарчмын хүрээнд эрчим хүчний хэрэглээ, хаягдлын хэмжээг бууруулах, байгаль орчны менежментийг сайжруулах, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр бодит ахиц гаргасан.

Эдгээр арга хэмжээний үр дүнд борлуулалтын орлого буурсан нөхцөлд ч нийт ашгийн түвшинг хадгалж, цэвэр ашгийг тогтвортой түвшинд байлгаж чадсан нь манай хамт олны нэгдмэл зорилго, хичээл зүтгэлийн илэрхийлэл юм.

Цаашид бид инновац, ногоон технологид суурилсан өсөлтийн стратегийг тууштай хэрэгжүүлж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, тогтвортой үнэ цэнийг бий болгоход чиглэн ажиллах болно.

Бидний үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажилладаг нийт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, түншүүд болон хичээл зүтгэл гарган ажиллаж буй нийт хамт олондоо чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,
Монгол Базальт ХК-ийн
Гүйцэтгэх захирал
А.Энхгэрэл



КОМПАНИЙН ТУХАЙ

Компанийн нэр	: Монгол Базальт ХК
Байгуулагдсан он	: 2007
Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл	: Эрдэс чулуун хөвөн барилгын материалын үйлдвэрлэл

Монгол Базальт ХК нь барилга, дэд бүтэц, эрчим хүч болон аж үйлдвэрийн салбаруудын эрчим хүчний хэмнэлттэй барилгын материалын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг базальт чулуун хөвөн дулаалгын материал үйлдвэрлэгч компани юм.

Тус компанийн бүтээгдэхүүнүүд нь олон улсын стандартад нийцсэн бөгөөд галд тэсвэртэй, байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй шинж чанараараа зах зээлд өрсөлдөх давуу талтай.

Алсын хараа

Галт уулын чулуулгийг чулуун хөвөн болгон хувиргаж, нийгэмд тулгарч буй уур амьсгалын өөрчлөлтийн томоохон сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, орчин үеийн амьдралыг баяжуулж, аюулгүй, эрүүл, уур амьсгалд илүү тэсвэртэй, тогтвортой нийгмийг цогцлооно.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Чулуун хөвөн дулаалгын материалын үйлдвэрлэл

Дулаан болон дуу тусгаарлалтын зориулалттай өндөр гүйцэтгэлтэй базальт чулуун хөвөн бүтээгдэхүүний үйлдвэрлэл.

Борлуулалт ба түгээлт

Дотоодын болон бүс нутгийн зах зээлд дулаалгын шийдлүүдийг гол зорилтот сегментүүдэд чиглүүлэн борлуулах, маркетинг хийх, түгээх.

Инженеринг ба техникийн дэмжлэг

Бүтээгдэхүүний техникийн үзүүлэлт тодорхойлох, хэрэглэх заавар зөвлөгөө өгөх, харилцагч болон түншүүдэд техникийн туслалцаа үзүүлэх.

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



УДИРДЛАГЫН БАГ

Олон түвшний удирдлагын загвараар үйл ажиллагаа явуулж, үр дүнтэй шийдвэр гаргах, зах зээлд өрсөлдөх чадвараа хадгалж байна.



А.Энхгэрэл
Гүйцэтгэх захирал



П.Батмөнх
Дэд захирал



Н.Сугарсүрэн
Ерөнхий нягтлан бодогч



Б.Уранбилэг
Борлуулалт, маркетингийн ахлах менежер



П.Баасан-Очир
Үйлдвэрийн дарга, Ерөнхий технологич



Х.Батдэлгэр
Ерөнхий инженер




Ж.Сүхбаатар
Засвар механикийн албаны дарга



Н.Сайнзаяа
Технологич инженер

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ПРОЦЕСС



БҮТЭЭГДЭХҮҮН



Чулуун хөвөн хавтан дулаан тусгаарлагч



Термобазальт шугам хоолой, үйлдвэрлэлийн дулаан тусгаарлагч



Базальтвүүл хэсэгчлэн угсрах сэндвич хавтан



Шүршдэг чулуун хөвөн дулаан тусгаарлагч



Пассив базальт панел бүтээц, хийц



Базальт арматур



Базальт чулуун хөвөн хөрс

Бүтээгдэхүүний гол шинж чанарууд:

- Галд тэсвэртэй байдал: A1 ангиллын шатдаггүй материал. 1000°C-ээс дээш хэмд тэсвэртэй тул барилгын хийцийг гал түймрийн аюулаас найдвартай хамгаална.
- Эрчим хүчний хэмнэлт: Дулаан дамжуулалт маш бага тул барилгын дулаан алдагдлыг 22% хүртэл бууруулж, эрчим хүчний зардлыг хэмнэнэ.
- Дуу тусгаарлалт: Сүвэрхэг бүтэц нь дуу чимээг өөртөө шингээж, тав тухтай орчныг бүрдүүлнэ.

- Байгаль орчинд ээлтэй: Байгалийн чулуунаас гаргаж авдаг тул хүний биед хорт нөлөөгүй, экологийн цэвэр бүтээгдэхүүн (Green Technology).
- Зэврэлтээс хамгаалах: Металл хийцийг чийг болон химийн нөлөөллөөс тусгаарлаж, зэврэлтээс хамгаалж ашиглалтын хугацааг уртасгана.

2026 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 онд нийт 2,100 тонн чулуун хөвөн дулаалгын материал үйлдвэрлэхээр төлөвлөж байна.

Бүтээгдэхүүний төрөл

Бүтээгдэхүүн	Хэмжээ (тн)	Хувь
Чулуун хөвөн хавтан	2,076	98.8%
Термобазальт цавуутай хөвөн	15	0.7%
Оёмол хөнжил хөвөн	9.5	0.4%
Нийт	2,100	100%

БОРЛУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Базальт ХК-ийн 2026 оны борлуулалтын төлөвлөгөө нь зах зээлд эзлэх байр суурийг хадгалах стратегийн зорилттой уялдуулан, бүтээгдэхүүний нэр төрөл, улирлын эрэлт, барилгын улирлын хэлбэлзэлд үндэслэн боловсруулагдсан болно.

Борлуулалтын стратеги нь гурван гол сегментэд чиглэгдэнэ:

1. Орон сууцны сегмент: Барилга компаниудтай урт хугацааны гэрээ байгуулж, галын хамгаалалтын стандартыг сурталчлах замаар борлуулалтыг нэмэгдүүлнэ.
2. Дэд бүтэц, эрчим хүчний сегмент: Mega projects-д нийлүүлэгчээр бүртгүүлж, төсөвт суурилсан тендерт идэвхтэй оролцоно.
3. Амины орон сууц / хувийн сууц хаус төслүүд: Агаарын бохирдол дахин дулаалгын аянуудад нэгдэх, эрчим хүчний хэмнэлтийн боловсролыг түгээх сурталчилах замаар борлуулалтыг нэмэгдүүлнэ.

Борлуулалтын стратеги (Segment by Segment)

Сегмент	Зорилтот SOM (10%) м³	Стратеги
Орон сууц, олон нийтийн үйлдвэр үйлчилгээний барилга	10,530	Барилгын компаниудтай урт хугацааны гэрээ байгуулах, галын хамгаалалтын стандартыг сурталчлах
Дэд бүтэц / Эрчим хүч	20,790	Mega projects-д нийлүүлэгчээр бүртгүүлэх, төсөвт суурилсан тендерт идэвхтэй оролцох
Амины орон сууц	3,780	Агаарын бохирдол дахин дулаалгын аянуудад нэгдэх, эрчим хүчний хэмнэлтийн боловсролыг түгээх сурталчилах замаар борлуулалтыг нэмэгдүүлнэ.
Нийт борлуулалтын хэмжээ /м³/	35,100 м³	Борлуулалтын орлого - 10.57 тэрбум төгрөг

Ашигт ажиллагааны (EBITDA) тооцоо

Үзүүлэлт	Тоо хэмжээ (тэрбум ₮)	Хувь (%)
Орлого	10.57	100%
Материалын өртөг	5.41	55%
Ажиллах хүч, логистик	1.97	20%
SG&A (захиргаа, маркетинг)	0.98	10%
EBITDA	1.47	15%

2026 оны борлуулалтын төлөвлөгөө нь 2025 оны гүйцэтгэлтэй харьцуулахад өсөлтийн зорилготой бөгөөд улирлын идэвхжил II болон III улиралд төвлөрөхөөр төлөвлөгдсөн.

2026 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ

ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

Эрсдэлийн удирдлагын бодлого

Компанийн 2026 оны стратегийн зорилт болох:

- Зах зээлийн 10%-ийн эзлэх хувь
- 2,000+ тонн үйлдвэрлэл
- 10+ тэрбум төгрөгийн борлуулалтын орлого
- EBITDA 15% түвшинд хадгалах

зорилтуудыг хангах хүрээнд эрсдэлийг урьдчилан тодорхойлж, үнэлж, бууруулах системтэй менежментийг хэрэгжүүлнэ.

Эрсдэлийн удирдлага нь:

1. Эрсдэлийг тодорхойлох
2. Нөлөөлөл, магадлалыг үнэлэх
3. Хариу арга хэмжээ боловсруулах
4. Хяналт, мониторинг хийх гэсэн үе шаттайгаар хэрэгжинэ.

ГОЛ ЭРСДЭЛҮҮДИЙН АНГИЛАЛ

<p>Зах зээлийн эрсдэл Эрсдэл:</p> <ul style="list-style-type: none"> • Барилгын салбарын идэвх буурах • Импортын хямд бүтээгдэхүүний өрсөлдөөн • Валютын ханшийн хэлбэлзэл <p>Нөлөөлөл: Борлуулалтын бууралт, үнийн дарамт</p> <p>Удирдлагын арга хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> • Mega project болон B2B гэрээний тоог нэмэгдүүлэх • Үйлдвэрлэлийн өртөг бууруулах (кокс, холбогч бодисын хэмнэлт) • Бүтээгдэхүүний ялгарал (галын аюулгүй байдал, үндэсний үйлдвэрлэгч давуу тал) • Урт хугацааны гэрээ байгуулах 	<p>Үйлдвэрлэлийн эрсдэл Эрсдэл:</p> <ul style="list-style-type: none"> • Тоног төхөөрөмжийн гэмтэл, гэнэтийн зогсолт • Түүхий эдийн чанарын хэлбэлзэл <p>Нөлөөлөл: Үйлдвэрлэлийн саатал, өртгийн өсөлт</p> <p>Удирдлагын арга хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> • Урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээ (Preventive Maintenance) • Сэлбэгийн стратегийн нөөц бүрдүүлэх • Түүхий эдийн хүлээн авах чанарын хяналтыг чангатгах • Хүчин чадлын ашиглалтыг 75%+ түвшинд барих
<p>Санхүүгийн эрсдэл Эрсдэл:</p> <ul style="list-style-type: none"> • Түүхий эд, түлшний үнийн өсөлт • Бараа материалын илүүдэл нөөц • Авлагын эргэн төлөлтийн удаашрал <p>Нөлөөлөл: Мөнгөн урсгалын дарамт</p> <p>Удирдлагын арга хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> • Cash flow төлөвлөлтийг улирлаар хийх • Авлагын кредит бодлогыг хатуу мөрдөх • Нөөцийн эргэлтийг сайжруулах • Өртгийн хяналтын KPI хэрэгжүүлэх 	<p>ХАБЭА болон Байгаль орчны эрсдэл Эрсдэл:</p> <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрийн осол • Тоосжилт, хаягдал, байгаль орчны зөрчил <p>Нөлөөлөл: Торгууль, үйлдвэрлэл зогсох</p> <p>Удирдлагын арга хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> • Эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх • Аюулгүй ажиллагааны сургалт • Тоос бууруулах системийн сайжруулалт • Байгаль орчны тайлагнал тогтмолжуулах
<p>Түүхий эд, ханган нийлүүлэлтийн эрсдэл Эрсдэл:</p> <ul style="list-style-type: none"> • Кокс, базальт нийлүүлэлтийн тасалдал • Ложистикийн саатал <p>Нөлөөлөл: Үйлдвэр зогсох эрсдэл</p> <p>Удирдлагын арга хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> • 2-3 сар хүртэлх стратегийн нөөц бүрдүүлэх • Олон нийлүүлэгчтэй байх бодлого • Гэрээний нөхцөлд нийлүүлэлтийн баталгааг тусгах 	<p>Хүний нөөцийн эрсдэл Эрсдэл:</p> <ul style="list-style-type: none"> • Мэргэшсэн ажилтны хомсдол • Ажилтны урсгал <p>Удирдлагын арга хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> • Сургалт, ур чадвар дээшлүүлэх хөтөлбөр • Урамшууллын систем • Ажиллах орчны сайжруулалт

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МАТРИЦ

Эрсдэл	Магадлал	Нөлөөлөл	Түвшин
Зах зээлийн бууралт	Дунд	Өндөр	Өндөр
Тоног төхөөрөмжийн эвдрэл	Дунд	Өндөр	Өндөр
Түүхий эдийн тасалдал	Бага-Дунд	Өндөр	Дунд
Мөнгөн урсгалын дарамт	Дунд	Дунд	Дунд
ХАБЭА зөрчил	Бага	Өндөр	Дунд

2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТОЙМ



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тайлант хугацаанд "Монгол Базальт" ХК нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх бодлогын хүрээнд нийт 1,833 тонн базальт чулуун хөвөн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулалтын бэлэн байдлыг ханган ажиллалаа.

- **Технологийн тохируулга:** Үйлдвэрийн дамжлагын тохиргоог сайжруулж, тоног төхөөрөмжийн туршилт, зүгшрүүлэлтийг амжилттай хийснээр үйлдвэрлэлийн технологийн алдагдлыг бууруулж, бүтээгдэхүүний өөрийн өртгийг хэмнэх боломж бүрдэв.
- **Стандартчилал:** Шүршдэг базальт (SMW) болон утаслаг базальт (FMW) материалын техникийн стандартыг (MNS) батлууллаа.



ХҮНИЙ НӨӨЦ БА АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

- **Хөдөлмөрийн аюулгүй байдал:** Тайлант хугацаанд үйлдвэрлэлийн осолгүй ажиллаж, ISO 45001, 14001, 9001 стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.
- **Мэргэшсэн хамт олон:** Инженер техникийн ажилтнуудыг олон улсын туршлага судлах сургалтад хамруулж, ажиллах хүчний тогтвор суурьшлыг (эргэц 2.5%) өндөр түвшинд хадгалав.



БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- Байгаль орчны менежментийн дотоод журам, хяналт-үнэлгээний тогтолцоог сайжруулж, ажилтнуудын мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх сургалт, зааварчилгааг тогтмол зохион байгууллаа.
- Үйлдвэрийн нийт эрчим хүчний хэрэглээ 681,504 кВт.цаг байсан нь өмнөх онтой харьцуулахад 20 % буурууллаа.




ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

ХУВЬЦААНЫ ХАНШ



ХУВЬЦААНЫ ХАНШИЙН ГРАФИК




Тайлант хугацаанд Монгол Базальт ХК-ийн үнэт цаасны хоёрдогч зах зээл дээрх хувьцааны арилжааны дээд ханш 209.99 төгрөг, доод ханш 161.03 төгрөг байсан бол 2025 оны хаалтын ханш 208.98 төгрөгт хүрсэн байна. Тайлант хугацаанд сард дунджаар 85,359 ширхэг хувьцаа арилжаалагдсан бөгөөд нийт 1,024,311 ширхэг хувьцаа 194.1 сая төгрөгийн үнийн дүнтэйгээр хоёрдогч зах зээл дээр арилжаалагдсан үзүүлэлттэй байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар тогтоолоор, нэгж хувьцаанд **2.61** төгрөгийн ногдол ашиг буюу нийт **147,248,370** төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн.

Өмнөх оны ногдол ашиг болох 136,529,140 төгрөгийг 2025 оны 5 дүгээр сарын 31-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд тараан байршуулсан.

1 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



2 НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭШИГЧИД

№	Нэр	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Л.Ариунболд	35.7%
2	П.Сайнбилэг	13.3%
3	А.Энхгэрэл	7%
4	А.Энхмаа	7%
5	А.Энхжин	7%




КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Монгол базальт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хараат бус гишүүдийн оролцоог ханган ажилладаг бөгөөд аудит, эрсдэлийн, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороодын тогтолцоогоор дамжуулан дотоод хяналт, ил тод байдал, хариуцлагын механизмыг бэхжүүлж, компанийн стратегийн хэрэгжилт, санхүүгийн гүйцэтгэл, эрсдэлийн удирдлагад үр дүнтэй хяналт тавин тогтвортой үнэ цэнийг бий болгоход чиглэн ажиллаж байна.

2025 оны компанийн засаглалын кодексын үнэлгээ:

90.2%



Компанийн ТУЗ нь 2025 онд ээлжит 4, ээлжит бус 1, эчнээ санал хураалт 2 удаа зохион байгуулж нийт 11 удаагийн шийдвэрийг гаргасан байна.

Компанийн ТУЗ-ийн дэргэд хяналт, нийцлийн ажилтан /комплайнс/ ажилладаг бөгөөд жилд 1 удаа үйл ажиллагааны бүхий л үе шатанд нийцлийн үнэлгээ хийж, ТУЗ-д танилцуулан үл нийцлийг арилгах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЙМ

Санхүүгийн үзүүлэлт

Нийт хөрөнгө	44,489,045,259
Өр төлбөрийн нийт дүн	13,463,349,984
Эзэмшигчдийн өмчийн дүн	31,025,695,275
Нийт гаргасан хувьцаа	56,417,000

Орлого үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Нийт борлуулалтын орлого	9,258,316,349
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	6,689,917,119
Нийт ашиг	2,568,399,230
Цэвэр ашиг	147,443,974
Нэгж хувьцааны дансны үнэ	550


Санхүүгийн харьцаанууд

Нийт хөрөнгийн өгөөж /ROA/	0.3314
Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROE/	0.4752
Нийт хөрөнгийн эргэц /ROTA/	0.2081
Нэгж хувьцааны өгөөж /EPS/	2.6135
Үнэ ашгийн харьцаа (P/E Ratio)	79.9627

Зах зээл ба борлуулалтын үйл ажиллагаа

Барилгын салбарын идэвхжил буурсантай холбоотойгоор зах зээлийн нийт эрэлт буурсан боловч компани харилцагчийн баазаа хадгалж, урт хугацааны гэрээт харилцааг үргэлжлүүлэв.

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ХАРЬЦУУЛАЛТ / САЯ.ТӨГРӨГ



нийгмийн хариуцлагын хүрээнд УИХ-ын гишүүн Г.Лувсанжамцын санаачлан хэрэгжүүлж буй “Дулаанбаатар” аяны хүрээнд, түүний ажлын хэсэг болон нийслэлийн 6 дүүргийн Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудтай хамтран 2000 гаруй иргэдэд эрчим хүчний хэмнэлтийн боловсрол олгох замаар дулаан алдагдлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй "Ногоон технологийг" сурталчлан таниулах сургалт, зөвлөгөө арга хэмжээг зохион байгууллаа.



Нексия Глобал Монголиа Аудит ХХК
Эмбасси Уян Бүлдинг, 606 тоот, 6-р давхар,
Элчлэгийн гудамж, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар, Монгол Улс

Утас: +976 7700 1500,
Веб хаяг: www.nexia.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

МОНГОЛ БАЗАЛТ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Аудиторын дүгнэлт

Бид Монгол Базальт ХК (цаашид "Компани" гэх)–ийн 2025 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")–өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"–ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"–ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг (үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлттэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)–ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"–ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид:




Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2026 оны 3 дугаар сарын 23-ны өдөр

МОНГОЛ БАЗАЛЪТ ХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	Тод	2025	2024
Борлуулалтын орлого	6	9,258,316	12,275,103
Борлуулалтын өртөг	7	(6,689,972)	(8,975,800)
Нийт ашиг		2,568,344	3,299,303
Бусад орлого	8	-	996
Бусад олз / (гарз)	9	287	(7,583)
Борлуулалт, маркетингийн зардал	11	(872,935)	(1,199,691)
Ерөнхий ба удирдлагын зардал	12	(437,727)	(335,891)
Бусад зардал	10	(27,107)	(302,027)
Үйл ажиллагааны ашиг		1,230,862	1,455,107
Хүүний орлого	13	1,217	200,399
Санхүүгийн зардал	13	(1,065,236)	(1,469,341)
Татварын өмнөх ашиг		166,843	186,165
Орлогын татварын зардал	24	(24,544)	(49,516)
ЦЭВЭР АШИГ		142,299	136,649
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (төгрөгөөр)		2.52	2.42

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



МОНГОЛ БАЗАЛЪТ ХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	Тод	2025-12-31	2024-12-31
ХӨРӨНГӨ			
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	14	29,919	21,961
Дансны авлага	15	226,658	455,936
Бусад авлага	16	214,582	204,983
Бараа материал	17	4,991,061	3,772,558
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	18	5,743,581	2,206,637
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	19	180,123	-
Нийт эргэлтийн хөрөнгө		11,385,924	6,662,075
Үндсэн хөрөнгө	20	22,194,637	24,972,601
Биет бус хөрөнгө	21	10,900,188	11,408,415
Хойшлогдсон татварын хөрөнгө		-	5,755
Нийт эргэлтийн бус хөрөнгө		33,094,825	36,386,771
НИЙТ ХӨРӨНГӨ		44,480,749	43,048,846
ӨР ТӨЛБӨР			
Дансны өр төлбөр	22	418,728	458,910
Бусад өр төлбөр	23	996,767	702,345
Орлогын татварын өр төлбөр	24.1	112,393	106,793
Бусад татварын өр төлбөр	25	3,424,116	2,214,595
Богино хугацаат зээл	26	4,807,791	3,837,317
Урьдчилж олсон орлого	27	387,842	124,782
Нөөц өр төлбөр	28	749,696	749,590
Цалингийн өр төлбөр	29	-	5,262
Нийт богино хугацаат өр төлбөр		10,897,333	8,199,594
Урт хугацаат зээл	26	2,562,865	3,833,857
Хойшлогдсон татварын өр төлбөр	24.2	-	614
Нийт урт хугацаат өр төлбөр		2,562,865	3,834,471
НИЙТ ӨР ТӨЛБӨР		13,460,198	12,034,065
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувьцаат капитал	30	5,641,700	5,641,700
Нэмж төлөгдсөн капитал	30.1	20,509,765	20,509,765
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		3,121,609	3,121,609
Хуримтлагдсан ашиг	30.2	1,747,477	1,741,707
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		31,020,551	30,014,781
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		44,480,749	42,048,846

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.





BASALTWOOL®
МОНГОЛ БАЗАЛТ ХК

МОНГОЛ БАЗАЛТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02-р сарын 16-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.4 заалт, 47 дугаар зүйлийн 47.1 заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2.6.12 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02-р сарын 16-ны өдрийн ээлжит хуралдааны дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол базальт” ХК-ийн 2025 оны жилийн эцсийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн татварын дараах цэвэр ашиг болох 147,443,973.91 төгрөгөөс нэгж хувьцаанд 2.61 төгрөг буюу нийт 147,248,370 төгрөгийн ногдол ашгийг хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Компанийн нийт гаргасан хувьцааны үндсэн 70% /39,491,900 ширхэг энгийн хувьцаа/-ийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг компаниаа, олон нийтэд эзэмшсэн 30% /16,925,100 ширхэг энгийн хувьцаа/-ийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх дансанд 2026 оны 04 сарын 30-ны өдрийн дотор олгохыг Гүйцэтгэх захирал /А.Энхгэрэл/-д зөвшөөрсүгэй.
4. Энэхүү тогтоолыг Монголын хөрөнгийн бирж, компанийн цахим хуудсаар дамжуулан нийт хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Билгүүн/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД

BASALTWOOL®
МОНГОЛ БАЗАЛТ ХК**МОНГОЛ БАЗАЛТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 03-р сарын 05-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Монгол базальт ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт гаргах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Компанийн дүрмийн 6-р бүлгийн 6.2.6.5 дах заалт, “Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг нэгдугаар хавсралтаар баталсугай.

2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД

“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

Монгол базальт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Монгол базальт ХК-ны дүрмээр тус тус тогтоогдсон эрх зүйн хэм хэмжээний хүрээнд компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг улирал тутам ТУЗ-ийн хурлаар авч үзэж, зохих удирдамж чиглэл өгч ажилласан болно, Түүнчлэн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм болон засаглалын зарчмын хүрээнд хянан хэлэлцэж, хувьцаа эзэмшигчдэд дараах дүгнэлтийг танилцуулж байна.

2025 онд 2165 тонн чулуун хөвөн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн ба борлуулалтын орлого 9,26 тэрбум төгрөг болж, өмнөх оны борлуулалтын орлогоос 24.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөнгөний бодлогын хатуу нөхцөл үргэлжилж бодлогын хүү өндөр түвшинд хадгалагдсан, инфляцын дарамт иргэдийн худалдан авах чадварын уналтаас улбаалж барилгын салбарын эрэлт саарсан, Монгол улс Евроазийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрт нэгдэн орсоноос хамаарч дулаалгын материалын зах зээлд өрсөлдөөн нэмэгдсэн зэрэг бизнесийн таатай бус хүчин зүйлс базальт бүтээгдэхүүний борлуулалт багасхад голлон нөлөөлсөн байна.

Гэсэн хэдий ч компанийн зүгээс түүхий эдийн худалдан авалтын оновчтой менежмент, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зардлын сахилга батыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд нэгж борлуулалт тутамд ноогдох үйлдвэрлэлийн өртөг 73.1 хувиас 72.3 хувь болж 0.8 пунктээр сайжирсан байна. Тухайлбал: тоног төхөөрөмжийн тохируулга, сайжруулалт хийснээр ажиллагаа жигдэрч төлөвлөгдөөгүй зогсолтыг байхгүй болгосон, импортын түүхий эдийн нөөцийг урьдчилан бэлтгэж зардлыг хэмнэх, үр ашиггүй зардлуудыг танах зэрэг арга хэмжээний үр дүнд уг ойролцоогоор 80 сая төгрөгийн ашиг хамгаалах боломжийг бий болгожээ. Үүний нөлөөгөөр нийт ашгийн хувь 2025 онд 27.7 хувь болж, тайлант үеийн цэвэр ашиг 147.4 сая төгрөг байгаа нь өмнөх оны түвшинд хадгалагдан эерэг гүйцэтгэл үзүүлэв.

Төлөөлөн удирдах зөвлөл нь тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй зах зээлийн, макро эдийн засгийн, санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлүүдийг үнэлэхэд ерөнхийдөө хяналттай түвшинд байсан бөгөөд компанийн удирдлагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь тогтвортой байдлыг хадгалахад чиглэгдсэн гэж үзэж болно.

Цаашид компанийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний дотоодын зах зээл дэх байр сууриа бэхжүүлэн өндөр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний эзлэх хувийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, зөвхөн бүтээгдэхүүний бус ажлын гүйцэтгэлтэй уялдуулан эцсийн үр дүнг борлуулах, технологийн шинэчлэлээр үр ашгийг нэмэгдүүлэх бодлогыг үргэлжлүүлэн ногоон барилга болон эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг эрчимжүүлэх, эрсдэлийн удирдлагын тогтолцоог идэвхижүүлэн ажиллах шаардлагатай гэж Төлөөлөн Удирдах Зөвлөл үзэж байна.

Иймд Монгол базальт ХК нь 2025 онд зах зээлийн тааламжгүй нөхцөлд үйл ажиллагаа явуулсан хэдий ч зардлын удирдлага, үйлдвэрлэлийн үр ашгийг сайжруулах, технологийн тохируулга, шинэчлэлийн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлснээр ашигт ажиллагааны түвшнийг хадгалж чадсан нь компанийн тогтвортой байдлын илэрхийлэл болсон гэж дүгнэлээ.

**“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04-р сарын 30-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд
Төлөөлөн удирдах зөвлөлийн өгсөн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9-д заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.11-д заалт, 2026 оны 04 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай

ХУРЛЫН ДАРГА

П.НЯМДОРЖ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТОВЧ НАМТАР



Лхагважавын Ариунболд

Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, Монгол улсын зөвлөх инженер

Мэргэжил: Цахиурын эрдэсийн ислийн хайлах болон дулаанаар боловсруулах хими технологийн инженер, Эдийн засагч

Боловсрол:

ЗХУ-ын Свердловск хотын Уралын Политехникийн дээд сургуулийн "Силикатын технологи" -ийн факультет

АНУ-ын Колорада мужийн Эдийн засгийн их сургууль

ОХУ-ын Уралын холбооны их сургуулийн Эрдмийн зэрэг хамгаалах зөвлөл- Эрдэс хайлуулах Вагранка зуухны модернизацийн шинэчлэл сэдвээр Техникийн Ухааны Доктор зэрэг хамгаалсан.

Ажил эрхлэлт ба туршлага:

1987-1990 он БЦУГ-ын засварын механикийн заводад Ерөнхий механик, Ерөнхий инженер

1990-1993 он Автомашины салхины шилний Төслийн удирдагч, төслийн үр дүнд Автомашины салхины шилний үйлдвэр Чин ХХК үүсгэн байгуулсан
1999-2012 он "Моншил" төслийн удирдагч, Төслийн үр дүнд Шилэн лонхны үйлдвэрийн төсөл хэрэгжүүлсэн.

2005 оноос чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэрийн төслийг санаачлагч, Төслийн удирдагч

2007-2018 он "Монгол Базальт" ХХК-ийн ийн үүсгэн байгуулагч, Ерөнхий захирал

2018 оноос "Монгол Базальт" ХК-ийн ТУЗ-ийн дарга



Хан гю бунг /Han kyu bong/

Мэргэжил: Бизнесийн удирдлагын мастер

Боловсрол:

1981-1985 БНӨСУ-ын Их сургууль- Бизнесийн удирдлагын бакалавр

2007 БНӨСУ-ын их сургууль- Бизнесийн удирдлагын мастер

Ажил эрхлэлт ба туршлага:

1999-2006 он Хьюндай- Салбарын дарга

2006-2013 он Гаүли инвестмент ХХК- Гүйцэтгэх захирал

2013 оноос Гаүли ҮЦК-ийн Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.

Тэрбээр үнэт цасны зах зээлийн салбарт 32 жил ажилласан туршлагатай бөгөөд БНСУ-ын үнэт цаасны зах зээл дээр 2,3 их наяд вон, МУ-ын үнэт цаасны зах зээл дээр 127 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төлвөрүүлсэн амжилттай ажиллаж байна.



Галбадрахын Ганзориг

Мэргэжил: Цэргийн командлагч, Улс төр судлаач

Боловсрол:

1976-1980 Одесс хотын ЦНДус

1990-1992 Улс төрийн дээд сургууль

2006-2008 БХИС-Удирдлагын академи

Ажил эрхлэлт ба туршлага:

1980-1992 онуудад Ардын армийн 138 дугаар ангид Салаа, Салбарын захирагч, дачилгаа эрхэлсэн штабын орлогч

1992-1994 он Зэвсэгт хүчний 084 дүгээр ангид Штабын орлогч

1994-1997 он Нийслэлийн цэрэг иргэний хамгаалалтын хэлтсийн Шуурхай албаны офицер

1997-2008 онуудад Нийслэлийн засаг даргын тамгын газрын цэргийн штабт Батлан хамгаалах хууль тогтоомж, хяналт шинжилгээ хариуцсан офицер

2008-2013 онуудад Нийслэлийн засаг даргын тамгын газрын цэргийн штабын орлогч дарга, Батлан хамгаалах хууль тогтоомж, хяналт шинжилгээ хариуцсан офицер

2016 оноос "Монгол Базальт" ХК-ийн Шугам хоолой дэд бүтцийн дулаалгын төслийн багийн удирдагч

2018 оноос "Монгол Базальт" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТОВЧ НАМТАР



Бадрахын Шаравсамбуу

Монгол улсын Гавьяат эдийн засагч

Мэргэжил: Эдийн засагч

Боловсрол:

1965 он Улаанбаатар худалдааны Техникум

1975 он Улс ардын аж ахуйн дээд сургууль

Москва хотын Маркетинг, эрэлт судлалын хүрээлэнгийн эрдмийн зэрэг хамгаалах зөвлөлд Эдийн Засгийн Ухааны Доктор зэрэг хамгаалсан.

Ажил эрхлэлт ба туршлага:

1965-1970 он Толгойт төв бараа бааз- Тооцооны, Ахлах, Орлогч нягтлан бодогч

1975-1979 он Худалдаа бэлтгэлийн яам- Ахлах мэргэжилтэн, Газрын дарга

1979-1984 он Худалдаа бэлтгэлийн яам- Орлогч сайд

1984-1990 он Худалдаа бэлтгэлийн яам-Сайд

1990 он Сайд нарын Зөвлөл- Орлогч дарга

1991-1994 он Москва хотод суугаа элчин сайдын яамны 1-р нарийн бичгийн дарга

1994-1996 он Гаалийн ерөнхий газрын Дарга

1996-1998 он Улаанбаатар импекс компани ТӨҮГ-Ерөнхий захирал

1996-2000 он Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн Маркетингийн тэнхимийн эрхлэгч

2000-2004 он Улсын их хурлын гишүүн

2005-2011 он Санхүүгийн зохицуулах хорооны Орон тооны гишүүн, дэд дарга

2019 оноос "Монгол Базальт" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн



Пүрэвбанзрагчийн Сайнбилэг

Мэргэжил: Технологийн инженер, Санхүүч

Боловсрол:

Политехникийн дээд сургууль- Технологийн инженер

СЭЗДС-Банк зээлийн эдийн засагч- Санхүүч

Ажил эрхлэлт ба туршлага:

2007-2018 он "Монгол Базальт" ХК-ийн Санхүү хариуцсан захирал

2018 оноос "Дулаан техникийн шинэчлэлийн төв" ХХК эрчим хүчний

аудитын байгууллагын Санхүү хариуцсан захирал

2018 оноос "Монгол Базальт" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн



Ариунболдын Энхгэрэл

Мэргэжил: Үйлдвэр үйл ажиллагааны менежмент,

Санхүү менежмент

Dale Carnegie Mentor Coach

Harvard Management Mentor

Боловсрол:

2014-2017 СЭЗИС- Санхүү менежмент

2008-2011 Лондон метрополитан их сургууль- Үйлдвэр үйл

ажиллагааны менежмент

Ажил эрхлэлт ба туршлага:

2008-2011 он Лондон " Луксотика" компанийн Кингстон салбарын менежер

2011-2012 он "Мянганы срилтын сан" - Crown Agents худалдан авах газрын менежер

2013-2017 он "Монгол Базальт" ХК-ийн Олон улсын төсөл хариуцсан захирал

2017-2018 он "Монгол Базальт" ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, үнэт цаас

хариуцсан мэргэжилтэн

2018 оноос "Монгол Базальт" ХК-ийн Гүйцэтгэх захирал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТОВЧ НАМТАР



Шаравсамбуу Энхтөр

Мэргэжил: Эрх зүйч, Банкны удирдлага

Боловсрол:

1987-1992 он Хилийн Цэргийн Командийн Дээд Сургууль-Командын
Офицер

1993-1997 он МУИС, Хууль Зүйн Их Сургууль- Эрх зүйч

2000-2004 он СЭЗИС-Банкны Удирдлага, Бизнесийн удирдлагын магистр

Ажил эрхлэлт ба туршлага:

1997-2009 он Худалдаа Хөгжлийн банк, Хуульч, Ахлах хуульч, Газар
хэлтсийн дарга

2009-2013 онд Хадгалам банкны Хуулийн газрын захирал

2013-2021 онд “Өмгөөллийн зөвлөх партнер” ХХК-ийн захирал, өмгөөлөгч

2021-2025 онд Ариг банкны Захиргаа, удирдлагын газрын захирал

2025 оноос Хөгжлийн банкны хэлтсийн захирал

2018 оноос "Монгол Базальт" ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн



Чансаа Зоригтбаатар

Мэргэжил: Хуульч, Эдийн засагч

Боловсрол:

СЭЗИС- Банк Санхүүгийн эдийн засгийн Бакалавр

ТУИС, Хууль Зүйн Их Сургууль- Хууль зүйн магистр, Эрх зүйч

Ажил эрхлэлт ба туршлага:

1996-1997 он Төрийн өмчийн хороо-Хуулийн зөвлөх

1997-1998 он Хууль зүйн дунд сургууль- Хичээлийн эрхлэгч

1998-2007 он Монгол Банк- Хуулийн хэлтэсийн мэргэжилтэн

2008 он Лекс Коунсел ХХК -Гүйцэтгэх захирал

2018 оноос "Монгол Базальт" ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн



Пүрэвсүх Нямдорж

Мэргэжил: Багш, Бизнесийн удирдлага

Боловсрол:

1996-2000 он Шонхор дээд сургууль- Багш

2008-2009 он Удирдлагын академи- Бизнесийн удирдлага

Ажил эрхлэлт ба туршлага:

2008 он Наран очир эрдэнэ ХХК-Захирал

2011-2012 он MWTS ХХК-Брокер

2013-2015 он Гацуурт трейд ХХК- Ахлах брокер

2015 он Монголын Хөрөнгийн бирж ТӨХК- Маркетингийн мэргэжилтэн

2022-2023 “Новел инвестмент ҮЦК” ХХК-ийн дэд захирал

2023-2024 “Новел ассет менежмент ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал

2024 оноос Монголын хөрөнгийн биржийн Бизнес хөгжил хариуцсан
ахлах мэргэжилтэн

2021 оноос "Монгол Базальт" ХК-ийн ТУЗ-ийн хараат гишүүн



Бат-Оргил Онон

Мэргэжил: Санхүү Удирдлага

Боловсрол:

2014-2018 он Санхүү Эдийн Засгийн Их сургууль -Санхүү удирдлага

Ажил эрхлэлт ба туршлага:

2018-2019 он "БиДиСЕК ҮЦК" ХХК-Харилцагчийн алба, Брокер

2019-2021 он "БиДиСЕК ҮЦК" ХХК- Харилцагчийн алба, Ахлах брокер

2021-2022 он "БиДиСЕК ҮЦК" ХК - Харилцагчийн алба, Менежер

2022-2023 он "БиДиСЕК ҮЦК" ХК - Харилцагчийн алба, Дэд захирал

2023-2025 он "БиДиСЕК ҮЦК" ХК - Харилцагчийн алба, Захирал

2025 оноос "БиДиСЕК ҮЦК" ХК - Гадаад харилцагчийн алба, Захирал

МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДҮГНЭЛТ

1. Үндэслэл

Монгол базальт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь Компанийн тухай хууль, компанийн дүрэм, Компанийн засаглалын кодекс болон Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн материалыг хянан хэлэлцэж, дараах дүгнэлтийг гаргав.

2. Нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид нь холбогдох хууль тогтоомжид заасан шалгуур шаардлагыг хангасан бөгөөд тэдгээрийн боловсрол, мэргэжил, ажлын туршлага, ур чадвар нь компанийн үйл ажиллагааны онцлог, стратегийн зорилттой нийцэж байна.

Нэр дэвшигчид нь:

- Удирдлага, санхүү, инженер техник, бизнесийн салбарт ажиллаж байсан туршлагатай
- Компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, стратегийн шийдвэр гаргалтын талаар мэдлэгтэй
- Ёс зүй, нэр хүнд, мэргэжлийн хариуцлагын шаардлагыг бүрэн хангаж байна

3. Хараат бус байдал, нийцлийн үнэлгээ

Нэр дэвшүүлэх хороо нь нэр дэвшигч бүрийн хараат бус байдал, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөлийг үнэлэхэд:

- Хараат бус гишүүнд нэр дэвшигч Ч.Зоригтбаатар, Ш.Энхтөр, Б.Онон, П.Нямдорж нар нь Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д заасан болон Компанийн засаглалын кодекс заасан хараат бус байдлын шалгуурыг хангаж байна.
- Нэр дэвшигчид нь компанийн үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчил үүсгэх нөхцөлгүй
- Ёс зүйн болон мэргэжил ур чадварын шаардлагад нийцэж байна.

4. Чадвар, ур чадварын үнэлгээ

ТУЗ-ийн нийт бүрэлдэхүүний хувьд дараах ур чадвар, туршлагын тэнцвэрийг хангах боломжтой гэж Нэр дэвшүүлэх хороо үзэв:

- Стратеги, бодлого боловсруулах чадвар
- Санхүү, аудит, эрсдэлийн удирдлагын мэдлэг
- Үйлдвэрлэл, инженерингийн салбарын ойлголт
- Олон улсын зах зээл, бизнесийн туршлага
- Засаглал, ёс зүйн ойлголт

5. Дүгнэлт

Дээрх үнэлгээний үр дүнд Нэр дэвшүүлэх хороо нь нэр дэвшигчдийг Монгол базальт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэхэд шаардлага хангасан, тохиромжтой гэж дүгнэв.

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04-р сарын 30-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Төлөөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7-д заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.9-д заалт, 2026 оны 04 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр

1. _____
2. _____
3. _____
4. _____
5. _____
6. _____нарыг тус тус сонгосугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр

1. _____
2. _____
3. _____нарыг тус тус сонгосугай.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм болон бусад хууль тогтоомжийг баримтлан компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

П.НЯМДОРЖ



 75114444

 monbasalt@rockwool.mn